

ДОТООД ХЯНАЛТ, ХУУЛИЙН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:							
<p>6.1.Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ. НЗДҮАХ –ийн 6.1.1, НХТЖҮЧ-ийн 9.1.1, НХЖТ-ний 6.1.1 Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.</p>							
1	2.1.2.Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг батлуулах	-	Бүсчлэлийн дүрэмд өгөх саналын тоо	Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийн төслийг боловсруулах суурь судалгаа хийгдсэн.	100	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/113 дугаар захирамжаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг 2022 онд 3 удаа хуралдаж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран эрдэмтэн судлаачидтай уулзалт зохион байгуулж газрын төлбөрийн бүсчлэлийн талаар мэдээлэл солилцон ажилласан. Улмаар 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Нийслэлийн тэг гортиг бүхий эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлт, эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийн төслийг боловсруулах ажлын талаар Улаанбаатар хотын Ерөнхий архитектор Н.Нацагдорж танилцуулга хийж Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн	100

						ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-тай уялдуул боловсруулахаар хойшлуулав.	
2	6.2.1.1.“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, Бүсийн хөгжлийн хөтөлбөртэй Нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулах	-	Саналын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/	60	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангаж, төслийн үе шатны тайланд санал өгч, холбогдох хэлэлцүүлэгт оролцож ажиллахаар тусгагдсантай холбогдуулан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын явц, үе шатны тайлан мэдээллийг ирүүлэх тухай хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/1030 дугаартай албан бичгийг Барилга, хот байгуулалтын сайдад хүргүүлсэн.	100
ХОЁР . ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД:							
Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:							
1	Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтаар баталсан аргачлал, загварын дагуу “Алсын хараа”, эрхэм зорилго, стратегийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн бүхий “Байгууллагын стратеги төлөвлөгөө 2021-2024”-ний төслийг нэгтгэн боловсруулж	100

						Газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. Хэлтсийн чиг үүрэгт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэн ажиллав	
2	2.1.НИТХ-ын 2014 оны 5/14 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилгын угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн батлуулах	-	Шинэчилсэн журмын тоо	НИТХ-ын 2014 оны 5/14	100	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгч УИХ-ын 2021 хаврын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулах үед Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулахаар буцаагдсан. Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцүүлгийн шатанд явагдаж байгаа бөгөөд тухайн хоёр хууль батлагдсаны дараа дагалдах норм стандарт, дүрэм журмыг болорвсруулах ажил хийгдэнэ. Нэгжийн дарга, ахлах мэргэжилтнүүдийг тус тус байлцуулан нийт 3 удаа хэлэлцүүлэг хийж, саналыг сонсож, журмын төсөлд дараах байдлаар тусгаж ажилласан. Үүнд: Журмын 1, 3, 4, 6, 7, 8, 9 дүгээр бүлэгт шинээр 11 заалт нэмж, 40 заалтад нэмэлт өөрчлөлт оруулан, 20 заалтыг шаардлагагүй гэж хасахаар тусгасан. Журмын төслийн “Төсөвт байгууллагад барилга барих зориулалтаар газар эзэмших эрх олгох” бүлгийн 2 дугаар зүйлийн 2.4.3 дахь “Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, үе шатны төсөлтэй уялдсан байна.”, 2.4.5 дахь “Нийслэлийн суурьшлын бүсийн хязгаарт орсон газрын эрх олгох асуудлыг зөвхөн Нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллага хариуцан зохион байгуулна.” гэсэн газрын харилцааг зохицуулж буй 2 заалтад өөрчлөлт оруулах саналыг нэмж	100

						тусгасан.“Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын зөвшөөрөл олгох, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам”-ыг хууль тогтоомжид нийцүүлэн Нийслэл хотын багц дүрмийн төсөлд оруулан батлуулахаар ажиллаж байна.	
3	2.10.1.Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хот төлөвлөлт, байгуулалт, барилгажилтын асуудлыг судалж санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн хурлыг байнгын ажиллагаатай зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тушаалаар Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хот төлөвлөлт, байгуулалт, барилгажилтын асуудлыг судалж санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх байнгын ажиллагаатай Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлагдав. Мэргэжлийн зөвлөлийн хурлыг тайлант хугацаанд 19 удаа зохион байгуулж хурлын жагсаалтыг газрын даргаар батлуулж, хурлаас гарсан санал, тэмдэглэлийг баталгаажуулан www.uda.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж, Архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулах ажлыг зохион байгуулалтаар хангаж ажиллав.Мэргэжлийн зөвлөл нийт 924 асуудал хэлэлцэж 505 дэмжигдсэн санал гарсан байна.	100
4	2.29.Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай холбогдох дүрэм, журмын төслийг шинээр боловсруулах, санал гаргах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай холбогдох дүрэм, журмын төслийг Нийслэлийн Засаг даргын 30 захирамжлалын баримт бичигт санал өгч ажиллав.	100

5	2.30.Хот байгуулалтын талаар хууль, дүрэм, журам холбогдох баримт бичигт санал тусгаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд санал өгч ажиллав.	100
6	2.31.Байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой хот байгуулалтын гэрээ, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төсөлд оролцогч талуудын гэрээ байгуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэх асуудлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл боловсруулж, барилга угсралтын ажил гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан 22 төсөл хэрэгжүүлэгчийн нийт 775 гурван талт гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулан ажиллав. өсөл хэрэгжүүлэгч гурван талт гэрээний үүргээ биелүүлж, Шинээр ашиглалтад оруулсан орон сууцаа Улсын комисст хүлээлгэн өгсөн “Кристал инженеринг” ХХК, “Алтан трейд” ХХК, “Асиан сити” ХХК төсөл хэрэгжүүлэгчийн 79 гэрээг дүгнэж архивд хүлээлгэн өгч ажиллав.	100
7	2.31.1.Хот байгуулалт, газрын дотоод үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хувийн хэргийг шилэн дансанд байршуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Хот байгуулалт дотоод үйл ажиллагааны чиглэлээр байгуулсан 21 гэрээг хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулав.	
8	2.32.Байгууллагын дүрмээр хүлээсэн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, үүсэх зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллан тайланг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн зөвлөмж	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Газрын 2022 оны Дотоод хяналт, шалгалтын ажлын 10 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулж, Захиргааны зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралд	

	гаргаж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллах				<p>танилцуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p> <p>Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон зөвшөөрөл олгосон барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээ, тохижилтын мэдээлэл хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэсэн байдлыг шалгах № Т2022/01 удирдамж газрын даргаар батлуулж хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэв. Шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг Захиргааны зөвлөлд танилцуулахаар бэлтгэн ажиллаж байна.</p> <p>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, мэргэжил ур чадварын талаар гаргасан гомдлын дагуу хяналт, шалгалт зохион байгуулж Авлигатай тэмцэх газрын 2, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 8, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 9, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 5, иргэн, хуулийн этгээдийн 25 нийт 49 өргөдөл, гомдлын барилгын норм дүрэм хангасан эсэх, шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж хариу өгч шийдвэрлэв</p>		
9	2.32.1.Газрын даргын захирамжлалын баримт бичиг, газраас гарч буй захиргааны актад цаасан болон цахим кодификаци хийх ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<p>Газрын даргын захирамжлалын болон бусад захиргааны актад кодификаци хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд 38 Архитектур төлөвлөлтийн даалгаварт, загвар зурагт кодификаци хийв.</p>	
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:							

1	3.2.Нэгжийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	2022 оны нэгжийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хагас жилээр тайлагнаж ажиллав.	100
2	3.2.1.Бодлогын баримт бичиг, Тогтоол шийдвэр хэрэгжилт болон 7, 14 хоног, сарын тайлан мэдээний биелэлтийг тайлагнаж ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Бодлогын баримт бичиг, Тогтоол шийдвэр хэрэгжилт болон 7, 14 хоног, сарын тайлан мэдээний биелэлтийг тайлагнаж ажиллав.	100
3	3.2.2.Нэгжийн үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт гаргаж тайлагнах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нэгжийн үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт улирал тутас гаргаж тайлагнаж ажиллав.	100
4	3.7.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 захирамжийн хүрээнд Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журмыг танилцуулга шторк хэлбэрээр бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчлах ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журмыг танилцуулга шторк хэлбэрээр бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллав.	100
5	3.2.9.Хууль, шүүхийн байгууллагад хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа нийслэлийн Засаг дарга болон газрын удирдлагын шийдвэртэй холбоотой эрх зүйн маргаанд итгэмжлэлээр оролцох		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Хууль, шүүхийн байгууллагад хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа нийслэлийн Засаг дарга болон газрын удирдлагын шийдвэртэй холбоотой 86 эрх зүйн маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож ажиллав.	100
6	3.2.10.Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа маргаан бүхий	-	Үйл ажиллагааны	100	100	Маргаан бүхий захиргааны актад холбогдох барилга байгууламжийн талаарх мэдээллийн хот байгуулалтын мэдээллийн менежментийн	100

	барилгыг хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, тэмдэглэгээ хийж, хэрэг маргаан дуустал ямар нэгэн шинээр акт болон бусад харилцаа явагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах		хэрэгжилт, хувь			системд бүртгэх, тэмдэглэх ажиллагааг цаг тухай бүрд хийж, холбогдох алба, хэлтэст мэдээлэн ажиллав.	
7	3.2.11.Шүүхэд төлөөлсөн байдал болон хэрэг хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны мэдээ, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Шүүхэд төлөөлсөн байдал болон хэрэг хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны мэдээ, тайланг 7 хоног тутам Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст тайлагнан ажиллав.	100
8	3.2.12.Маргаан бүхий хэрэгт газрын болон нотлох баримтын үзлэг хийхэд шүүх байгууллага болон бусад байгууллагатай хамтран оролцох		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Маргаан бүхий хэрэгт газрын болон нотлох баримтын үзлэг хийхэд шүүх байгууллага болон бусад байгууллагатай хамтран оролцож ажиллав. Тайлант хугацаанд архивын үзлэгт 3, маргаан бүхий газрын үзлэгт 21 удаа тус тус оролцов.	100
9	3.2.13.Газрын даргын тушаал, эрх зүйн шинжтэй бусад баримт бичгийн төсөл боловсруулахад оролцож, боловсруулсан төсөл, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах, нийцүүлэх талаар санал өгөх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Газрын даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 30, хүний нөөцтэй холбоотой 57 тушаалын төслийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж ажиллав.	100
10	3.2.14.Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 2021 онд хийгдсэн “Авлига, хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн хяналт, шалгалт”-ын дүгнэлтийн дагуу цаашид авах арга хэмжээний саналын дагуу 23 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжилтийн мэдээг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт заасан хугацаанд	100

						хүргүүлэв. Нийслэлийн Дотоод Аудитын албанаас 2021 онд хийгдсэн Хот байгуулалт хөгжлийн газрын 2019-2021 оны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтын ажлын тайлангийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хүргүүлэв.	
11	3.2.15.Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах		Сургалтад хамрагдсан цаг /1 албан хаагч/	1 албан хаагчийн сургалтад хамрагдсан цаг дунджаар 60 цаг	1 албан хаагчийн сургалтад хамрагдах цаг дунджаар 40 цагаас багагүй байх	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын эрх зүйн албан хаагчдад зориулсан хуулийн сургалтад хэлтсээрээ хамрагдаж нэгжийн дарга “Нийслэлийн харъяа агентлагуудад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт илтгэл тавив. Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон газрын хэмжээнд зохион байгуулсан 27 удаагийн сургалтад хэлтсийн албан хаагчид давхардсан тоогоор хамрагдсан болно.	100
12	3.13.1.Албан бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэлтийг	-	Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	9 хоног	Тус хэлтэст тайлант улиралд 294 албан бичиг ирж Хариу өгч шийдвэрлэсэн 208 шийдвэрлэх шатанд 13 хариугүй 72 шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6.7 хоног.	100
13	3.13.2.Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг EDOC системээс хэвлэн, архивлах - Ирсэн бичгийн бүртгэл хяналтын картыг хэвлэх, цахимаар ирсэн бичгийг бүртгэл хяналтын картын хамт EDOC системээс хэвлэн, архивлах (үндсэн үйл ажиллагааны чиглэлээр)	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	100	Тайлант улиралд нэгжид 294 албан бичиг EDOC системээр хүлээн авч бичиг судлан хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж бүртгэлийг системээс хэвлэн архивлан ажиллав.	100
14	3.13.3.Албан бичгийн цахим архив үүсгэх	-	Үйл ажиллагааны	Үгүй	Тийм	Тайлант улиралд нэгжид 294 албан бичиг EDOC системээр хүлээн авч бичиг судлан хууль	100

			хэрэгжилт, гүйцэтгэлээр			тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж дотоод сүлжээнд байршуулж ажиллав.	
15	3.14.1.Шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, эцэслэн шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	8 хоног	Ирсэн албан бичиг, өргөдөл гомдлыг судлан шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, эцэслэн шийдвэрлэж ажиллав.	100
	3.2.17.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарийн дагуу газрын архивд 14 хадгаламжийн нэгж үүсгэн хүлээлгэн өгөв.	100
ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:							
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтцийн чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ.							
1	Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд I-UP мэдээллийн цонхыг тогтмол ажиллуулах	-	I-UP мэдээллийн цонхонд мэдээ мэдээлэл байршуулсан	-	2 /Өссөн дүнгээр /	Барилга, байгууламжийг мэдээллийн санд бүртгүүлэх, хаяг дугаар хүсэх үйлчилгээний танилцуулга, цаасаар болон цахимаар хүсэлтээ илгээх заавар бүхий 6 минутын I UP мэдээллийг бэлтгэхэд хамтран оролцов.	100
2	Хот байгуулалтын үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган захиргааны сөрөг акт гарсан тохиолдолд бүртгэлжүүлж мэдээлж ажиллах.	-	Сөрөг актын тоог бууруулсан байдал: Архитектур төлөвлөлтийн даалгаврын тоо	21	/Сөрөг актын тоог 5 хувиар бууруулсан байна/	Захиргааны сөрөг акт гарах тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу эрх ашиг нь хөндөгдөж буй 12 иргэн, хуулийн этгээдэд сонсох ажиллагааг явуулж 5 байршилд захиргааны акт нийслэлийн Засаг даргын захирамжаар хүчингүй болгож 7 байршлын захиргааны актыг түдгэлзүүлсэн шийдвэр гарсаныг мэдээлж ажиллав.	100
3	Итгэмжлэлээр төлөөлөн оролцож байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	-	Үйл ажиллагааны	80	80	Итгэмжлэлээр төлөөлөн оролцож байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буй шүүх хурлын хуваарь бусад холбогдох цахим	100

	явагдаж буй шүүх хурлын хуваарь бусад холбогдох цахим мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулах, шинэчлэх, албан хаагчдыг мэдээллээр хангах		хэрэгжилт, хувь			мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулах, шинэчлэх, албан хаагчдыг мэдээллээр ханган ажиллав.	
4	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	НИТХ-ын 2014 оны 5/14 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилгын угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн батлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгана.	100
			Бусад тоо				

ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4
ХАГАС ЖИЛИЙН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ			
2	Дотоод ажил	Ажлын хэсэг	Нийслэлийн Засаг даргын захирамж болон газрын даргын тушаалаар байгуулагдсан 15 ажлын хэсэгт орж ажиллаж байна.
		Сургалт, уулзалт	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын эрх зүйн албан хаагчдад зориулсан хуулийн сургалтад хэлтсээрээ хамрагдаж нэгжийн дарга “Нийслэлийн харъяа агентлагуудад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт илтгэл тавив.

		Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон газрын хэмжээнд зохион байгуулсан 27 удаагийн сургалтад хэлтсийн албан хаагчид давхардсан тоогоор хамрагдсан болно.
	Бусад	Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилгүй ажиллав

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төсвийн шууд захирагч

Газрын дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Ц.Тулга/

Тэмдэг

.....
(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Үнэлгээний багийн дарга

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Ч.Бадамханд/

.....
(огноо)

Тайлагнасан:

Нэгжийн дарга

Дотоод хяналт, хуулийн
хэлтсийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Я.Болор/

.....
(огноо)